



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/ЗНБ

Арвайхээр сум

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохион  
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг орон нутагт бүртгэж зөвшөөрөл олгох, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын Эдийн засгийн албаны ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Мөнгөн зээлийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

6223 11 0658

D:My Doc. Zahiramj. Zasag darga